



МОНГОЛ УЛСЫН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН  
ЗАХИРАГЧИЙН ДЭРГЭДЭХ ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны санхүүгийн  
үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар гаргасан зөвлөмжийн тухай


Засгийн газрын 2012 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод аудитын дүрмийн  
хоёрдугаар зүйлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны 2012-2014 оны төсвийн  
санхүүжилт, төрийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, үр дүнд Хүнс, хөдөө аж ахуйн  
яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын санхүүгийн аудит хийсэн  
тайлантай танилцаж, аудитын хороогоор хэлэлцүүлсэн зөвлөмжийг хавсралтад тусгасанаар  
хэрэгжүүлсүгэй.

2. Зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах удирдлагын хариу арга хэмжээний  
төлөвлөгөө боловсруулан, 2015 оны 05 дугаар сарын 20 -ны дотор Хяналт-шинжилгээ,  
үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын  
захиргааны дарга /Р.Баярсайхан/-д үүрэг болгосугай.

3. Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хяналтад авч ажиллахыг Хүнс,  
хөдөө аж ахуйн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /У.Сауле/-  
д үүрэг болгосугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ



Р.БУРМАА

АЙМАГ ДУНДЫН ОТРЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ГАРГАСАН  
ЗӨВЛӨМЖИЙН ТУХАЙ

Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 11 дүгээр сарын 25 -ны өдрийн удирдамжийн дагуу Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод аудит хийсэн дүгнэлт, зөвлөмж:

НЭГ. АЙМАГ ДУНДЫН ОТРЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЗАХИРГААНД:

1. ТЭДСантай тооцоо нийлж, тус байгууллагаас холбогдох эрх зүйн акт, гэрээний дагуу шилжүүлж авсан 222902689.00 төгрөгийн хөрөнгийг байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд, 257619276.00 төгрөгийн өрийг өглөгийн тайланд тусган баталгаажуулах;

2. Мал хамгаалах сантай холбогдох 44982000.00 төгрөгийн өрийг тооцоо нийлж өглөгийн тайланд, тус сангаас шилжүүлсэн хөрөнгөнөөс бүртгэлд тусгалгүй үлдсэн 19982366.00 төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөнд бүртгэж, 25000000.00 төгрөгийн зээлийг Хайрхан бар ХХК, Архангай аймгийн “Тариалан эрхлэлтийг дэмжих дундын үйлчилгээний техникийн төв”-өөс авлагаар тусган тайлан тэнцэлд залруулга хийх;

3. ТЭДСангийн дэргэдэх яамны амралтад шилжүүлсэн 3-н нэр төрлийн 6 ширхэг 25509150.00 төгрөгийн хөрөнгийг байгууллагынхаа хөрөнгийн бүртгэлээс хасаж, тус байгууллагын тайлан тэнцэлд тусгуулах ажлыг зохион байгуулж, дотоодын хяналтыг сайжруулах;

4. ХХААХҮЯ-наас 2011 онд КОИКА ОУ-ын байгууллагаас “Халх голын бүс нутагт Хөдөө аж ахуйг сэргээн хөгжүүлэх мастер төлөвлөгөө” төслийн шугамаар олгосон “Power6000D-TM” маркийн өрмийн машин, HJP900/350-.N0903055 маркийн компрессорыг бүртгэл тайланд тусгах асуудлыг холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

5. Үндсэн ажилчдын орон тоог үйл ажиллагааны чиглэлтэйгээ уялдуулан төлөвлөн батлуулах, тухай бүр авч ажиллуулах гэрээт ажилчдын орон тоог оновчтой зохион байгуулах;

6. Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Жишиг норм батлах тухай” 19 тоот тушаалын 11 дүгээр хавсралтаар батлагдсан “Автомашин үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм”-ыг мөрдөж автомашины засвар үйлчилгээний зардалд хяналт тавьж ажиллах;

7. Өөрийн орлогын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг сайжруулах, санаачлагатай ажиллаж, өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах.

ХОЁР. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ СТРАТЕГИЙН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАРТ:

1. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд хийгдсэн санхүүгийн дотоод аудитаар тогтоогдсон 222288055.00 төгрөгийн хөрөнгийг “үндсэн хөрөнгийн данс бүртгэлд” тусгах, 25509150.00 төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж холбогдох байгууллагад шилжүүлэх, 302601276.00 төгрөгийн өрийг “өглөгийн тайлан”-д, 25000000.00 төгрөгийн авлагыг “авлагын тайлан”-д нэмж тусгах, нийт 757398481.00 төгрөгийн зөрчлийг арилгуулах, хяналт тавьж ажиллах;

2. Төсөл, хөтөлбөр, тендерээр нийлүүлэгдсэн хөрөнгийг тайлан тэнцэлд бүрэн тусгуулах, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, өр авлагын баталгаажуулалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ  
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР